“ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 02 дугаар сарын 16-ны өдөр | Дугаар ТУЗ2026-03/01 | Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйл, “Жуулчин Дюти Фрий” ХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.8.10, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 28-р тогтоол, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн шийдвэрийг тус тус үндэслэн ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛӨӨС ТОГТООХ НЬ:

1. “Жуулчин Дюти Фрий” ХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх үйл ажиллагааны цэвэр ашиг болон хуримтлагдсан ашгаас нэгж хувьцаанд ногдох хэмжээг 4,280 /дөрвөн мянга хоёр зуун наян/ төгрөгөөр тооцож нийт 279,749,360 /хоёр зуун далан есөн сая долоон зуун дөчин есөн мянга гурван зуун жаран/ төгрөгийг хувьцаа эзэмшигч нарт ногдол ашиг болгон мөнгөн хэлбэрээр хуваарилахыг зөвшөөрсүгэй.
2. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гарах бүртгэлийн өдрийг хувьцаа эзэмшигчдийн хурлын бүртгэлийн өдрөөр тасалбар болгон тогтоосугай.
3. Энэхүү тогтоолын 2 дахь хэсэгт заасан ногдол ашгаас холбогдох хууль тогтоомжийн дагуу албан татварыг суутган тооцож “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-иар дамжуулан хувьцаа эзэмшигч нарт 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн дотор тараасугай.
4. Энэхүү тогтоолд заасан ногдол ашгийг нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид арилжааны банк дахь дансанд шилжүүлж авахаар бичгээр хүсэлт гаргаж ногдол ашгийг авах боломжтойг дурдсугай.
5. Ногдол ашиг хуваарилалтын тайланг ногдол ашиг хуваарилж дууссан өдрөөс хойш ажлын 15 өдрийн дотор гаргаж Санхүүгийн зохицуулах хороонд тайлагнахыг Гүйцэтгэх захирал (Ц.Отгонбаяр), Ахлах нягтлан бодогч (Ч.Мөнхзул) нарт үүрэг болгосугай.
6. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс ногдол ашиг хуваарилах болсон тухай шийдвэр, шалтгааныг хувьцаа эзэмшигчдийн дараагийн зарлагдах хуралд танилцуулахыг Гүйцэтгэх захирал (Ц.Отгонбаяр), Ахлах нягтлан бодогч (Ч.Мөнхзул) нарт үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА ..... Ц.БААТАРСАЙХАН